




2024 JUNE

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 42.1%-ИАР, НИЙТ ЗАРДАЛ 41.3%-ИАР ӨСӨЖ ТӨСВИЙН ТЭНЦЭЛ 2 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН АШИГТАЙ ГАРЛАА.

Төсвийн орлого 12 их наяд төгрөгт хүрч өсөхөд орлогын албан татвар 1.6 (70.4%) их наяд төгрөг, НӨАТ 532.7 (30.9%) тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 376.8 (25.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн голлон нөлөөлжээ. Харин улсын төсвийн зардал 5 сарын байдлаар 10 их наяд төгрөгт хүрч өссөн нь 40 орчим хувийг төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмж бүрдүүлж байна.

ИНФЛЯЦ 5.7% ГАРЧ СҮҮЛИЙН 6 САР ТӨВ БАНКНЫ ЗОРИЛТОТ ИНТЕРВАЛД ХАДГАЛАГДЛАА.

Он гарснаас хойш инфляцын хурд саарч улсын хэмжээнд 5.7%-д хүрснээр өмнөх оны мөн үеэс 5.2 пунктээр буурсан байна. Хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 6.6% өссөн бол хүнсний бус бүлгийн үнэ 5.3% өсжээ. Цаашлаад хэрэглээний бараа үйлчилгээний сагсанд нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээ байдгаас 221 (46%) нь импортын бараа бөгөөд эдгээрийн инфляцид үзүүлсэн нөлөө 2% буюу нийт 5.7%-ийн 35% нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ ӨМНӨХ ОНООС 28.1%-ИАР ӨСӨЖ 39.1 ИХ НАЯД ТӨГРӨГ ХҮРСЭН БАЙНА.

- Ийнхүү өсөхөд төгрөгийн хадгаламж 4.9 их наяд төгрөг, төгрөгийн харилцах 1.8 их наяд төгрөг, гадаад валютын харилцах 2.6 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн бол долларын хадгаламж 800 тэрбумаар буурч 4.4 их наяд хүрчээ.
- Банкны салбарын зээл өмнөх оны мөн үеэс 28.2%-иар өсөж 31.1 их наяд төгрөгт хүрчээ. Зээлийн өсөлтийн 11.4%-ийг хэрэглээний болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт бүрдүүлж байгаа бол 5.7%-ийг ипотекийн зээл, 7.5%-ийг бусад салбарын зээлийн өсөлт бүрдүүлсэн байна.
- Харин хуримтлалын санд төвлөрсөн 500 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэр болгосноор 5 сарын байдлаар нийт 117,448 мянган зээлдэгчдэд 8.3 их наяд төгрөгийн ипотекийн зээл олгоод байна.

ОН ГАРСНААС ХОЙШ МАНАЙ УЛС 50 МЯНГА ГАРУЙ МАШИН ИМПОРТОЛЖЭЭ.

Манай улсын импорт 5 сарын байдлаар 4.4 тэрбум ам долларт хүрч өмнөх оноос 27%-иар буюу 932 сая доллароор өсжээ. Иргэдийн цалин тэтгэвэр нэмэгдэж, өрхийн орлого сайжирснаар хэрэглээ нэмэгдсэн нь импортын өсөлтийн гол шалтгаан болжээ. Харин нийт импортын 38% нь автомашин, тоног төхөөрөмж, сэлбэгийн импорт байгаа бөгөөд нийт импортолсон автомашины тоо хэмжээ 50 мянга хүрч өмнөх оноос 104%-иар өссөн байна. Харин дизель түлшний импортын хэмжээ 670 мянган тонн-д хүрч өмнөх оноос 26%-иар өссөн байна.

НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ 31.6 САЯ ТОННД ХҮРЧ ӨМНӨХ ОНООС 38%-ИАР ӨСЛӨӨ.

Нийт экспортын орлого 5 сард өмнөх оны мөн үеэс 50 сая ам.доллароор нэмэгдэж 6,356 сая долларт хүрснээр өмнөх оны экспортын орлогын түвшинд байна. Экспортын орлогын 60%-ийг нүүрсний экспорт бүрдүүлж байгаа бөгөөд 5 сарын байдлаар бид нийт 31.6 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оноос 38%-иар өссөн үзүүлэлт боллоо. Харин олон улсын зах зээл дээр нүүрсний үнэ тогтмол буурсаар байгаа бөгөөд 5 сарын нүүрсний үнэ 115\$ болж өмнөх оны мөн үеэс 18.6%-иар буураад байна. Харин зэсийн экспортын орлого 13%-иар өсөж 562 сая ам.долларт хүрээд байна.

ХЯТАДЫН АРДЫН БАНКТАЙ ХИЙСЭН СВОП ХЭЛЦЛЭЭС 4.5 ТЭРБУМ ЮАНИЙГ ЭРГЭН ТӨЛЛӨӨ.

Монголбанк 2011 онд Хятадын ардын банкт 2 орны худалдааг дэмжих, богино хугацааны хөрвөх чадварын нэмэгдүүлэх үндсэн зорилгоор анх 5 тэрбум юань буюу 1 их наяд төгрөгийн гэрээ хийж байсан. Тус хэлцлийн дүнг 2012 болон 2014 онуудад тус бүр 5 тэрбум юаниар нэмэгдүүлж 15 тэрбум юань болгож байсан бөгөөд гадаад валютын нөөц түүнээс хойш 2016 онд хамгийн доод түвшиндээ буюу 1.2 тэрбум ам.доллар хүрч байх үед тус хэлцлийн ашиглалтыг 12 тэрбумд хүргэж үүнээс хойш 3 жилээр жил бүр сунгаад байсан билээ. Харин 2023 онд тус хэлцлийн 1.5 тэрбум, энэ 6 сард 4.5 тэрбумын эргэн төлөлт хийснээр ашиглалтын хэмжээ 6 тэрбум юань болж буураад байна.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q1	2023Q4	2023Q1	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	6,065	30,454	5,624	7.8%
Гадаад өр	сая ам доллар	35,003	34,570	33,563	4.3%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M05	2024M04	2023M05	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	6,417	4,998	6,306	1.8%
Зэс	сая ам доллар	1,151	872	1,096	5.0%
Нүүрс	сая ам доллар	3,817	2,988	3,627	5.2%
Нийт импорт	сая ам доллар	-4,395	-3,426	-3,463	26.9%
Хэрэглээ	сая ам доллар	-1,258	-986	-1,009	24.7%
Түүхий эд	сая ам доллар	-382	-304	-327	16.8%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-1,837	-1,393	-1,393	31.9%
Шатахуун	сая ам доллар	-910	-738	-729	24.9%
Тэнцэл	сая ам доллар	2,022	1,572	2,843	-28.9%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	10,117	9,446	8,243	22.7%
Нүүрс	\$/тонн	148	137	179	-17.4%
Газрын тос	\$/баррель	83	89	76	9.6%
Алт	\$/трой унц	2,351	2,334	1,990	18.1%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,882	2,087	1,395	34.9%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	11,926	9,873	8,504	40.2%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-10,044	-7,786	-7,108	41.3%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M05	2024M04	2023M05	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	39,074	38,127	30,495	28.1%
ХҮИ (C2015)	индекс	145.0	144.0	137.1	5.7%
Бодлогын хүү	%	11.0%	12.0%	13.0%	-15.4%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,381	3,377	3,448	-1.9%
Төгрөгийн хадгаламж	%	11.4%	11.4%	11.2%	2.2%
Валютын хадгаламж	%	4.6%	3.4%	3.3%	38.2%
Төгрөгийн зээл	%	16.9%	17.2%	16.9%	-0.2%
Валютын зээл	%	9.3%	9.1%	9.5%	-3.0%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	5,183	4,986	3,897	33.0%
Үнэт цаас	сая ам доллар	2,663	2,237	597	345.8%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	1,916	2,165	2,774	-30.9%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	-0.6%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	97	100	114	-14.5%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	500	476	405	23.4%


БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.